



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/142

Мөрөн сум

Газар өмчлөх эрхийг дуусгавар
болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Иргэн Доёд овогтой Баатар /PE60031574/ -нь өөрийн хүсэлтээр газар өмчлөх эрхээсээ татгалзаж байгаа тул аймгийн Засаг даргын 2012 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн А/95 дугаар захирамжийн хавсралтын 1461 дугаар хэсгийг хүчингүй болгож Монгол улсын иргэнд нэг удаа газар үнэгүй өмчлөх эрхийг дуусгавар болгосугай.

2. Газар өмчлөх эрхээсээ татгалзсан иргэний газрыг улсын бүртгэлээс хасахыг аймгийн аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул)-т даалгасугай.

3. Мөрөн сумын Засаг даргын 2007 оны 08 сарын 27-ний өдрийн №96 дугаар захирамжийн иргэн Д.Баатар-д холбогдох хэсэг болон газар эзэмших 0126164 тоот гэрчилгээг хүчин төгөлдөр хэвээр үлдээсүгэй.

4. Аймгийн Засаг даргын энэхүү шийдвэрийг оролцогчид эс зөвшөөрвөл мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурьдсугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН